

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ЗӨВЛӨМЖ

**СҮМБЭР СУМАНД ХЭРЭГЖИХЭЭР ШИНЭЭР БАТЛАГДСАН ДЭД ХӨТӨЛБӨРТ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ**

2018 оны 03 дугаар сар 02

Чойр хот

Нэг. Нийтлэг үндэслэл

Сумын дэд хөтөлбөр нь сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг мөн бөгөөд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хоёр. Зорилго

Сумын дэд хөтөлбөр нь бодлогын баримт бичигтэй уялдаж, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцсэн эсэх, орон нутгийн дунд хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгаж батлуулсан эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан алдаа дутагдалд заавар зөвлөмж өгч, арга зүйгээр ханган баримт бичгийн боловсруулалтыг сайжруулахад оршино.

Гурав. Нэр томъёоны тайлбараас

/Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиас/

1. “Дэд хөтөлбөр” гэж Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичгийг:
2. “Хөгжлийн бодлогын баримт бичиг” гэж үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэл, орон нутгийн түвшинд урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг:

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Сүмбэр сумын 2018 онд шинээр 2 дэд хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 128 дугаар тогтоолоор “Соёл урлаг, спорт, нийгмийн салбаруудад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөр”, мөн өдрийн 129 тогтоолоор “Байгаль хамгаалах дэд хөтөлбөр” баталдсан байна.

Хөтөлбөрийн санхүүжилтийг 2018 оны төсвийн “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардалд хөтөлбөрийг дэмжих санхүүжилт гэж тус бүрт 10,0 сая төгрөгийг тусгаж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоолоор батлуулжээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр сумын Засаг дарга 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/10 дугаар захирамжаар “Соёл урлаг, спорт, нийгмийн салбаруудад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөр” –ийг 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 12 арга хэмжээ тусгаж, 10,0 сая төгрөгийн төсвийн задаргааг, 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/07 дугаар захирамжаар “Байгаль хамгаалах дэд хөтөлбөр”-ийг 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 12 арга хэмжээ тусгаж, 5 арга хэмжээнд 10,0 сая төгрөгийн төсвийн задаргааг тус тус баталсан.

Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн 2 дэд хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлэгээ хийж үзээд боловсруулсан дэд хөтөлбөр нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15.1, 15.6, 17, 18 дугаар зүйлүүд, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 52, 54, 55 дугаар зүйлүүдийн шаардлагыг хангаагүй, хэрэгжих боломжгүй хөтөлбөр, дахин боловсруулалт хийх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

1. Дэд хөтөлбөрийн ерөнхий мэдээлэл бичигдээгүй, яагаад энэ хөтөлбөрийг боловсруулах болсон шалтгаан, өнөөгийн тулгамдаж байгаа асуудал, үндэслэл, нөхцөл байдлын дүн шинжилгээний дүн, хамрах хүрээг тодорхойлоогүй байна.
2. Дэд хөтөлбөрийн зорилго, зорилт нь бүрийг хэрэгжүүлснээр дунд хугацаанд нийгэм, эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд ямар үр нөлөө үзүүлэх нь тодорхойгүй байна.
3. Дэд хөтөлбөрийн бүтээгдэхүүн бүрт 1-ээс доошгүй шалгуур үзүүлэлтийг тодорхойлох ба батлагдсан хөтөлбөр нь үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг гаргаагүй байна.

4. Дэд хөтөлбөрийг дунд хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөө байхгүй, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг хөтөлбөрийн зорилт тус бүрээр тусган тооцоогүй.
5. Дэд хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон арга хэмжээ нь хоорондоо уялдахгүй байна. Тухайлбал: Соёл урлаг, спорт, нийгмийн салбаруудад чиглэсэн хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ нь хоорондоо уялдаагүй, хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхээр 6 зорилт дэвшүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээг 4 чиглэлд тодорхойлсон нь дэвшүүлсэн зорилтыг бүрэн хангахуйц байж чадахгүй дутуу тодорхойлсон.
6. Дэд хөтөлбөр нь сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэгдээгүй. Өөрөөр хэлбэл сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт “Байгаль хамгаалах хөтөлбөр батлах тухай, Соёл урлаг, спорт, нийгмийн салбаруудад чиглэсэн хөтөлбөр батлах тухай” гэсэн зорилт тусгагдаагүй байна. Дэд хөтөлбөрийн зорилго нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэсэн байх ёстой.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Аймаг, нийслэл, сум дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэл, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо эх үүсвэрийг тодорхойлсон байна” гэж заасан. Гэтэл сумын шинээр хэрэгжихээр батлагдсан 2 дэд хөтөлбөр нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Иймд хөтөлбөрийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 21.4.1-д, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 66 дугаар зүйлд заасны дагуу дунд хугацааны бодлогын баримт бичигт нэмэлт оруулж, дэд хөтөлбөрийг хууль журамд нийцүүлэн боловсруулж батлуулахад дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй. Үүнд:

1. Дэд хөтөлбөр нь сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг ба тул

- хөтөлбөрийн зорилгыг бусад бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилттой уялдуулах, нийцүүлэх
2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт тус бүрээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох
 3. Дэд хөтөлбөрийн зорилго, зорилт бүрийг хэрэгжүүлсний үр дүнд бий болох эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тодорхойлох
 4. Дэд хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг бусад бодлогын баримт бичиг, статистикийн мэдээ, салбарын мэдээлэлд үндэслэн тодорхойлох
 5. Шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, суурь он, зорилтот түвшин болон он, мэдээллийн эх сурвалжийг тодорхойлсон байх
 7. Дэд хөтөлбөрийн дунд хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг хөтөлбөрийн зорилт тус бүрээр тусгаж батлуулах

Жич: Дэд хөтөлбөрийг хуульд журамд нийцүүлж боловсруулаагүй, бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулаагүй тохиолдолд хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөрөнгийг зарцуулахгүй байхыг анхааруулж байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын ХШҮДАХ-т ирүүлнэ үү.

ХЯНАСАН:

ХШҮДАХ-ИЙН ДАРГА

Х.БУЯНБАЯР

ХШҮ ХИЙСЭН:

ХШҮДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

П.НАРАНМАНДАХ